



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 97

Номгон

Үл хөдлөх хөрөнгө, тээврийн
хэрэгслийн дуудлагын худалдааны
доод үнийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2.2, 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус XIII хуралдааны 13/03 дугаар тогтоолын хавсралтын 1, 3 дугаар мөр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 10 дугаар тогтоолын хавсралтын 6 дугаар мөр, 100 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар мөрүүдэд заасан Баянговь, Богд сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилгууд, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг хавсралтад заагдсны дагуу дуудлагын худалдаагаар худалдах доод үнийг 50 хувиар бууруулж дуудлагын худалдаагаар худалдсугай.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Барилга, автомашины нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 11⁰⁰ цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 03 тоот өрөөнд зохион байгуулж, орлогыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд төвлөрүүлэх;

2.2. Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 05 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар сарын
19-ний өдрийн 27 дугаар тогтооллын хавсралт

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДУУДЛАГЫН
ХУДАЛДААНЫ ДООД ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООСОН ЖАГСААЛТ

| № | Сумын нэр | Байгууллагын нэр | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон он | Тоо ширхэг | Тоо хэмжээ | Газрын хэмжээ /м2/ | Худалдах доод үнэ |
|-------------------------------|------------------|------------------|-------------------------------|---------------------|-----------------------|-------------------------|------------------------|--|
| Барилга байгууламж | | | | | | | | |
| 1 | Баянговь сум | ЗДТГ | Халуун усны дуусаагүй барилга | 2011.01.01 | 1 | 110м2 | 116.7м2 | 7500000,00 |
| 2 | Богд сум | ЗДТГ | Цэлгэр 4-р багийн барилга | 2007.12.30 | 1 | 32м2 | 100м2 | 1450000,00 |
| Дүн | | | | | | | | |
| Авто тээврийн хэрэгсэл | | | | | | | | |
| № | Аймаг, сумын нэр | Байгууллагын нэр | Тээврийн хэрэгслийн төрөл | Марк | Улсын бүртгэлийн сери | Улсын бүртгэлийн дугаар | Ашиглалтад орсон огноо | Дуудлагаар худалдах хөрөнгийн доод үнэ |
| 1 | Баацагаан сум | ЗДТГ | Суудлын автомашин | УАЗ-315122 | БНА | 52-39 | 2015.12.01 | 500000,00 |
| 2 | Баянхонгор аймаг | Нэгдсэн эмнэлэг | Суудлын автомашин | Nissan advan | БНА | 94-88 | 2009.11.25 | 400000,00 |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |
| | | | | | | | | 900000,00 |
| | | | | | | | | 9850000,00 |

000